

## ӨМНӨХ ҮГ

“Монголын хүн амын сэтгүүл” нь хүн ам зүй болон хүн ам, хөгжлийн асуудлаар Монгол Улсад хийгдсэн эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд, мэргэжлийн тооцоо, шинжилгээний онол, техник, арга зүйн сургалтууд, асуудал хөндсөн шүүмж, үзэл бодлыг хөгжлийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, мэргэжилтэн, олон улсын донор байгууллагууд, судлаачид, оюутнууд болон сонирхсон бусад олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор бэлтгэгддэг.

Сэтгүүл нь хянан магадлагаа хийгддэг, монгол болон англи хэлээр холимог байдлаар хэвлэгддэг Монгол Улсын Их Сургуулийн эрдмийн бичиг юм.

Монголын хүн амын сэтгүүлийг 1996 оноос хойш тасралтгүй хэвлэмэл байдлаар бэлтгэн тархааж байсан бол 2023 оноос эхлэн хэвлэмэл болон онлайн хэлбэрээр олны хүртээл болгохоор бэлтгэл ажлууд хийгдэж байна. Сэтгүүлийн өмнөх бүх дугаарыг МУИС-ийн төв номын санд хэвлэмлээр, номын сангийн цахим хуудаст PDF хэлбэрээр байршуулсан ба 2023 оны 05 дугаар сараас эхлэн МУИС-ийн сэтгүүлийн нэгдсэн сан болох <https://journal.num.edu.mn/MJP/index> цахим хуудаст байрлуулан уншигчиддаа хүрэх хүртээмжийг нэмэгдүүлсэн болно.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт нийт 8 судалгаа, шинжилгээний бүтээлийг толилуулж байна. Эдгээрээс онцолбол, МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээнээс “Асрахуйн эдийн засаг” сэдвийн хүрээнд зохион байгуулагдах “Эмэгтэйчүүдийн нүдээр” Үндэсний чуулганд зориулан тусгайлан бэлтгэсэн зарим судалгаа багтсан болно. Тэдгээрт асрахуйн эдийн засгийн асуудлыг хөндөж, цалин хөлсгүй асрах ажлыг мөнгөн дүнгээр хэмжин, ДНБ-д эзлэх хувь хэмжээг тооцож үнэлсэн тоон шинжилгээ бүхий бүтээл багтсан. Мөн феминист идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын үнэт зүйл, зорилгод нийцсэн оролцооны арга зүйг ашиглан хийсэн дөрвөн сэдэвчилсэн чанарын судалгааны үр дүн танилцуулагдаж байна. Эдгээрээс гадна хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгааллын салбар дахь зарим асуудлыг нотолгоонд суурилан дүгнэсэн сонирхолтой үнэлгээнүүдийн үр дүнтэй уншигч Та танилцаарай.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн бүтээлээ ирүүлнэ гэдэгт бид итгэж байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол Улсын Их Сургуульд сэтгүүлийн редакцын зөвлөл гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ